



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 06 өдөр

Дугаар A/168

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2018 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэл, ажлын хэсгийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимиийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2018/2019 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн мөрдсүгэй.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан), Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Н.Ганзориг), бүрэлдэхүүн сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ректорын 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/22 тоот тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимиийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Б.ОЧИРБАТ





ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Их сургуулийн алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд салбар, тэнхимиин үйл ажиллагааг хөгжүүлэн төгөлдөржүүлэх, тэдгээрийг шинээр зохион байгуулах, татан буулгах, профессор, багшийг тухайн албан тушаалд сонгон шалгаруулж ажиллуулахтай холбогдсон харилцааг "Боловсролын тухай хууль", "Дээд боловсролын тухай хууль", "ШУТИС-ийн дүрэм", "ШУТИС-ийн хөдөлмөрийн дотоод журам" болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн зохицуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.
2. Бүрэлдэхүүн сургуулийн салбар, тэнхимиин сургалт, эрдэм шинжилгээний ажлын онцлогт тохирсон зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт хийх, профессор, багш нарын ажлын байранд тавигдах шаардлагын биелэлтийг хянаж, үнэлгээ дүгнэлт өгөх, ажлын үр дүнгээр албан тушаалын зэрэглэл, шатлалд өөрчлөлт оруулах, албан тушаалын орон тоог жил бүр шинэчлэн тогтоо замаар багш нарыг чадваржуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

ХОЁР. ИХ СУРГУУЛИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1. Мэргэжлийн салбар (цаашид салбар гэх) нь шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн, бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдийг хариуцан хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа явуулах, түүний чанар, түвшинг их сургуулийн хүрээнд болон нийгмийн өмнө хариуцан ажиллах, бүтээлч сэтгэлгээ, шинэ санааг хөгжүүлэх, зохион бүтээх авьяас чадварыг дэмжин нийгэмд үйлчлэх үүрэг бүхий их сургуулийн зохион байгуулалтын үндсэн нэгж байна.
- 2.2. Тэнхим нь тухайн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрүүдэд тусгагдсан тодорхой суурь шинжлэх ухааны болон нийтлэг сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, нийгэмд үйлчлэх үндсэн үүрэг бүхий их сургуулийн зохион байгуулалтын үндсэн нэгж байна.
- 2.3. Салбар, тэнхимийг шинэчлэн зохион байгуулах, шинээр байгуулах болон татан буулгах асуудлыг бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.4. Салбар, тэнхим нь ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталсан албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.
- 2.5. Салбар, тэнхимийн эрхлэгч өөрийн үйл ажиллагаанд туслуулах зорилгоор профессор багш наарт тодорхой чиг үүргийг хуваарилан хариуцуулан ажиллуулж болно.
- 2.6. Эрдэм шинжилгээ, судалгааны үндсэн нэгж болох судалгааны профессорын багийг салбар, тэнхим болон бүрэлдэхүүн сургууль дунд



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт

байгуулж ажиллуулах ба үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулна. Салбар, тэнхимиин багш нар судалгааны профессорын багт давхар харьяалагдах боломжтой ба салбар, тэнхимиин эрхлэгч судалгааны профессорын багийг давхар удирдахгүй.

- 2.7. Салбар, тэнхимиин хурлыг багш нарын гуравны хоёроос доошгүй ирцтэй хийж, хэлэлцэх асуудлыг олонхийн саналаар батлан тэмдэглэл хөтлөнө. Санал тэнцсэн тохиолдолд салбар, тэнхимиин эрхлэгчийн саналаар шийдвэрлэнэ.
- 2.8. Салбар, тэнхимиин үйл ажиллагааны санхүүжилтийг бүрэлдэхүүн сургуулийн төсөвт тусгаж батална.
- 2.9. Салбар, тэнхимиин үйл ажиллагааны тайланг бүрэлдэхүүн сургуулийн Захирлын зөвлөлөөр хэлэлцэж дүгнэх ба салбар, тэнхимиин эрхлэгчийн ажлын үр дүнд холбогдох дүгнэлтийг хамтатган гаргана.

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Салбар, тэнхим нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, нийгмийн үйлчилгээний үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
Үүнд:

I. Салбарын хувьд:

- 3.1.1. Салбар нь бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт явуулах, хөтөлбөрийн үр дүн, чанарт байнгын дүн шинжилгээ, өөрийн үнэлгээ хийж, дотоодод болон олон улсын түвшинд магадлан итгэмжлүүлэх;
- 3.1.2. Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах болон шинэ хөтөлбөр нээх, хөтөлбөрийг зогсоох талаар хөтөлбөрийн дэд хороонд санал хүргүүлэх, хичээлийн стандартыг боловсруулах;
- 3.1.3. Мэргэжлийн салбарын суралцагчдыг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, иргэний соёл төлөвшүүлэх, мэргэжлийн уралдаан, соёл, олон нийтийн ажил зохион байгуулах болон оюутны сайн дурын байгууллага, дугуйлан, клубыг дэмжин ажиллах;
- 3.1.4. Сургууль-төгсөгч-ажил олгогчийн холбоог бэхжүүлж, төгсөгчдийг насан туршийн сургалтанд хамруулах, тэдэнтэй тогтвортой хамтран ажиллах механизм бүрдүүлэх болон төгсөгчдийн мэргэжлийн чадвар болон сургалтын хөтөлбөрт санал авах, хамтарсан сургалт, судалгаа явуулах зэргээр ажил олгогчидтой хамтран ажиллах;

II. Тэнхимиин хувьд:

- 3.1.5. Тэнхим нь тухайн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрүүдэд тусгагдсан тодорхой суурь шинжлэх ухааны хичээлийн стандартыг боловсруулах, сургалт явуулах;



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт

- 3.1.6. Сургалтын хөтөлбөрт тодорхой суурь ~~шинжилэх~~ ухааны хичээлтэй холбоотой өөрчлөлт оруулах талаар хөтөлбөрийн дэд хороонд санал хүргүүлэх;
- 3.1.7. Суралцагчдыг эрдэм шинжилгээний ажлын арга барилд сургах, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэх, иргэний соёл төлөвшүүлэх, уралдаан, олимпиад, соёл, олон нийтийн ажил зохион байгуулах;

III. Салбар, тэнхимиийн нийтлэг чиг үүрэг, үйл ажиллагаа:

- 3.1.8. Салбар, тэнхимиийн хөгжлийн чиг хандлага, үнэт зүйл, зорилго, зорилтыг урт ба дунд хугацаагаар төлөвлөх, бизнес болон стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттай зохион байгуулах;
- 3.1.9. Салбар, тэнхимиийн үйл ажиллагааны төсвийн төлөвлөлтийн саналыг боловсруулах;
- 3.1.10. Суралцагчдыг суралцах таатай орчин болон сургалтын иж бүрэн материалаар хангах, сургалт, судалгааны материаллаг баазыг шинэчлэх, шинээр байгуулах, мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага, заавар боловсруулах ажлыг нэгдсэн төлөвлөлтийн зохион байгуулах;
- 3.1.11. Профессор багш нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, багшлах бүрэлдэхүүнийг чанаржуулах, эрдэмжүүлэх, мэргэжлийн сургалт, заах арга зүйг сайжруулах ажлыг нэгдсэн удирдлагаар ханган зохион байгуулах;
- 3.1.12. Сургалтын бус үйл ажиллагаанаас орох орлогыг нэмэгдүүлэх, профессор багш нарын туршилт судалгаа явуулах орчин нөхцлийг сайжруулах, эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн эх үүсвэр бий болгох;
- 3.1.13. Эрдэм шинжилгээний семинарыг судалгааны чиглэлээр тогтмол явуулах (улиралд 2-оос доошгүй), мэргэжлийн сургалт-заах арга зүй, эрдэм шинжилгээ, онол практикийн хурлыг зохион байгуулах, судалгааны үр дүнг дотоод болон гадаадад хэвлэн нийтлүүлэх;
- 3.1.14. Профессор багш болон салбарын бусад ажилтны ажлын чиг үүрэг, албан тушаалын зэрэглэл, шаталыг тогтоох, өөрчлөх санал гаргах, багш, ажилтны ёс зүйн болон сахилгын зөрчилтэй холбогдсон хариуцлага тооцох санал гаргах;
- 3.1.15. Нийгэм, олон нийтэд чиглэгдсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ, үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд явуулах;
- 3.1.16. Монгол улсын ба тодорхой салбарын урт, богино хугацааны хөгжлийн бодлого, төсөл, хөтөлбөр, боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтран оролцох, зөвлөгөө өгөх, төрийн болон холбогдох мэргэжлийн байгууллага, гадаад, дотоодын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагатай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 3.1.17. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, салбар, тэнхим, судалгааны профессорын багуудтай үйл ажиллагааг уялдуулан хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр зохион байгуулах;



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт

- 3.1.18. ШУТИС-ийн дүрэм, журамд өөрчлөлт оруулахтай холбоотой саналыг бүрэлдэхүүн сургуулиар дамжуулан гаргах;
- 3.1.19. Салбар, тэнхимиийн түүхийн хуанлийг хөтлөх, холбогдох мэдээ тайлан, судалгааг цаг тухай бүр гаргах;
- 3.1.20. ШУТИС-ийн дүрэм, журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

ДӨРӨВ. МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 4.1. Салбарт харьялагдах сургалтын хөтөлбөрүүд, салбар, тэнхимиийн багш нарын тоо, сургалтын материаллаг бааз, лаборатори зэргээс хамаарч тухайн албан тушаалд харгалзах орон тоог ялгаатай тогтооно.
- 4.2. ШУТИС-ийн салбар, тэнхимиийн албан тушаал нь дараах ангилалтай байна.

I. Эрхлэгч:

- 4.2.1. Салбарын эрхлэгч
- 4.2.2. Тэнхимиийн эрхлэгч

II. Багш:

- 4.2.3. Зөвлөх профессор
- 4.2.4. Профессор
- 4.2.5. Дэд профессор
- 4.2.6. Ахлах багш
- 4.2.7. Багш
- 4.2.8. Дадлагажигч багш

III. Бусад:

- 4.2.9. Сургалтын мастер
- 4.2.10. Эрхлэгчийн туслах

4.3. Зөвлөх профессор:

Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, Ардын болон Гавьяат цолтон, Төрийн соёрхолт, Шинжлэх ухааны академийн академич, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор цолтой, гадаад, дотоодод нэр хүнд бүхий, тухайн салбарт тэргүүлэх эрдэмтдийг бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн салбар, тэнхимд зөвлөх профессороор ажиллуулж болно.

4.4. Профессор:

- 4.4.1. Доктор(Sc.D) болон доктор(Ph.D)-ийн эрдмийн зэрэгтэй, профессор цолтой эрдэмтнийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн профессорын албан тушаалд ажиллуулна.
- 4.4.2. Доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй, дэд профессор цолтой эрдэмтнийг судалгааны ажлын үр дүнг харгалзан профессорын албан тушаалд ажиллуулж болно.

ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт



4.5. Дэд профессор:

- 4.5.1. Доктор (Ph.D)-оос доошгүй эрдмийн зэрэгтэй, дэд профессор цолтой эрдэмтнийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн дэд профессорын албан тушаалд ажиллуулна.
- 4.5.2. Доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалаад ШУТИС-д 2-оос доошгүй жил амжилттай ажилласан залуу эрдэмтэн болон эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан эрдэмтнийг дэд профессорын албан тушаалд ажиллуулж болно.

4.6. Ахлах багш:

- 4.6.1. Их сургуулийн багшийн албан тушаалд үр бүтээлтэй ажилласан, доктор (Ph.D)-ын зэрэгтэй багшийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн ахлах багшийн албан тушаалд ажиллуулна.
- 4.6.2. Их сургуулийн багшийн албан тушаалд үр бүтээлтэй 15 жилээс дээш ажилласан багшийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн ахлах багшийн албан тушаалд ажиллуулж болно.
- 4.6.3. Багшийн сонгон шалгаруулалтанд тэнцсэн, доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалан багшлах ажилд шинээр орж байгаа залуу эрдэмтэн болон бусад их, дээд сургууль, коллежид ахлах багшаас доошгүй албан тушаалд ажиллаж байсан доктор (Ph.D)-ын зэрэгтэй багшийг ахлах багшийн албан тушаалд ажиллуулж болно.

4.7. Багш:

- 4.7.1. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, үндсэн мэргэжлийн дагуу эрдэм шинжилгээний байгууллага, үйлдвэрлэл, бусад их, дээд сургууль, коллежид 5-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан хүнийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн багшийн албан тушаалд ажиллуулж болно.
- 4.7.2. Багшийн албан тушаалын шаардлагыг хангасан дадлагажигч багшийг бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн багшийн албан тушаалд дэвшүүлэн ажиллуулна.

4.8. Дадлагажигч багш:

- 4.8.1. Багшийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, дадлагажигч багшийн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлага хангасан хүнийг дадлагажигч багшийн албан тушаалд 1 жилээс доошгүй хугацаагаар ажиллуулна.
- 4.9. Салбар, тэнхимийн эрхлэгч болон бусад албан тушаалтан нь дор дурьдсан үндсэн чиг үүргээс гадна ШУТИС-ийн Захирлын баталсан ажлын байрны тодорхойлолтонд заагдсан бусад ажил үүргийг хариуцан гүйцэтгэнэ.

- 4.9.1. Салбарын эрхлэгч нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, хүний нөөц, багшлах бүрэлдэхүүн, залгамж халааг бэлтгэх, салбарын хөгжлийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх ба гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэл, оюутны хөгжлийн асуудлыг хариуцан салбарын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 4.9.2. Тэнхимиийн эрхлэгч нь сургалтын хөтөлбөрт тусгагдсан суурь шинжлэх ухааны сургалтыг хэрэгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах, материаллаг баазыг бэхжүүлэх, багшлах бүрэлдэхүүн, хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэх ба гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэн, тэнхимиийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 4.9.3. Зөвлөх профессор нь салбар, тэнхимиийн үйл ажиллагааг хөгжүүлэх, профессор багш нарт мэргэжлийн, арга зүйн зөвлөгөө өгөх, онолын семинар явуулах, мэргэжлийн хичээл заах, нэг сэдэвт бүтээл, ном, сурах бичиг бичих, эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, докторант, магистрантуудын судалгааны ажлыг удирдах ажлыг гүйцэтгэнэ.
- 4.9.4. Салбарын профессор нь магистр, докторын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хариуцах, мэргэжлийн хичээл заах, сургалт, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр ном, сурах бичиг, бүтээл бичиж туурвих, докторант, магистрантуудын судалгааг удирдах ажлыг гүйцэтгэнэ.
- 4.9.5. Тэнхимиийн профессор нь бүх шатны мэргэжилтэн бэлтгэх сургалтад оролцох, е-сургалтыг хөгжүүлэх, сургалт, эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр ном, сурах бичиг, бүтээл бичиж туурвих болон эрдэм шинжилгээ, судалгааны тодорхой чиглэлийг хариуцан ажиллана.
- 4.9.6. Дэд профессор нь бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах, бүх шатны мэргэжилтэн бэлтгэх сургалт, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох, удирдах, тухайн салбарын сургалтын материал, ном сурах бичгийн хангамжийг сайжруулах болон е-сургалтын үйл ажиллагааг хариуцна.
- 4.9.7. Ахлах багш нь бүх шатны сургалтанд хичээл заах, ном сурах бичиг, гарын авлага бичиж боловсруулах, сургалтын шинэ арга технологи нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцох, удирдах үйл ажиллагааг хариуцна.
- 4.9.8. Багш нь бакалавр, магистрын мэргэжилтэн бэлтгэх сургалтад хичээл заах, ном сурах бичиг, гарын авлага бичиж боловсруулах, эрдэм шинжилгээ судалгааны ажилд оролцоно.



- 4.9.9. Дадлагажигч багш нь бакалаврын түвшний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцон хичээл зааж, багшлах ажлын дадлага, ур чадвар эзэмшинэ.
- 4.9.10. Сургалтын мастер нь сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, анги танхим, лабораторийг хариуцан, багш нарын ажилд дэмжлэг үзүүлэн, бакалаврын түвшний дээд боловсролын суурь болон мэргэжлийн суурь ухааны хичээлийн хөтөлбөрийн дагуу лабораторийн хичээл заана.
- 4.9.11. Эрхлэгчийн туслах нь салбар, тэнхимиин үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад эрхлэгчийн өдөр тутмын үйл ажиллагаанд туслах, албан хэрэг хөтлөлт хариуцах, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулах анги танхим, зохион байгуулалтын нөхцлийг бүрдүүлж, багш нарын ажилд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 4.10. Салбар, тэнхимд харьялагдах сургалтын хөтөлбөрүүд, заах мэргэжлийн курс, хичээлүүд, багш нарын тоо зэргээс хамаарч зөвлөх профессор, профессор, дэд профессорын албан тушаалд харгалзах орон тоог тогтооход дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 4.10.1. Бүрэлдэхүүн сургууль, институтын хэмжээнд ажиллах зөвлөх профессорын орон тоо 3 хүртэл байж болно.
 - 4.10.2. Тухайн салбарт ажиллах профессорын орон тоог хариуцан хэрэгжүүлж буй ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн тоо, эрдэм шинжилгээ, судалгааны үндсэн чиглэл, профессор багш нарын болон суралцаж буй оюутны тоотой уялдуулан хичээлийн жил бүрийн эхэнд ШУТИС-ийн Захирал тогтооно.
 - 4.10.3. Тухайн салбарт ажиллах дэд профессорын орон тоог хариуцан хэрэгжүүлж буй бакалаврын түвшний сургалтын хөтөлбөр, суралцаж буй оюутны тоотой уялдуулан ШУТИС-ийн Захирал тогтооно.
 - 4.10.4. Тэнхимиин нийт үндсэн багшийн тоо 30-аас бага үед 1 профессор, 1 дэд профессор, нийт үндсэн багшийн тоо 31 буюу түүнээс их үед 2 хүртэл профессор, 2 хүртэл дэд профессор ажиллуулж болно.
 - 4.10.5. Ахлах багш, багш, дадлагажигч багшийн хувьд тухайн албан тушаалын орон тоог хязгаарлахгүй.
 - 4.10.6. Салбар, тэнхимд гадаадын зочин профессор ажиллуулж болох бөгөөд ажиллах албан тушаалын зэрэглэл, ажлын ачааллыг ШУТИС-ийн Захирлын тушаалаар тогтооно.
 - 4.10.7. Хичээлийн жилийн төгсгөлд ШУТИС-ийн өөрийн үнэлгээний систем дэх үзүүлэлт, ажлын үр дүн, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн саналыг үндэслэн, дараагийн хичээлийн жилд ажиллах профессор багш нарын албан тушаалын ангиллыг ШУТИС-ийн Захирлын тушаалаар шинэчлэн баталж мөрдөнө.
 - 4.10.8. ШУТИС-ийн хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг тухайн жилийн 7-р сарын 1-ний өдрөөс дараа жилийн 6-р сарын 30-ны өдөр хүртэлх хугацаагаар тооцно. Хичээлийн жилийн намрын улирал нь



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт

9-р сарын 1-ний өдрөөс дараа оны 1-р сарын 31-ний өдөр хүртэл,
хаврын улирал нь 2-р сарын 1-ний өдрөөс 6-р сарын 30-ны өдрийг
хүртэл үргэлжилнэ.

ТАВ. ШУТИС-ИЙН МЭРГЭЖЛИЙН САЛБАР, ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧИЙГ ТОМИЛОХ, БАГШИЙН АЛБАН ТУШААЛД СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ

- 5.1. Салбар, тэнхимиийн эрхлэгчийн албан тушаалд мэргэжлийн чиглэлээр тухайн салбартай нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлж чадах, шинийг санаачилж багаар ажиллах чадвартай, доктор (Ph.D), дэд профессороос доошгүй зэрэг, цолтой эрдэмтдээс ШУТИС-ийн Захирал томилно.
- 5.2. Салбар, тэнхимиийн эрхлэгч нь “Салбар, тэнхимиийг хөгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулж, тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирлаар батлуулан, хичээлийн жил бүр салбар, тэнхимиийн хамт олноор хэлэлцүүлж, ажлын үр дүн, биелэлтийг дүгнүүлнэ.
- 5.3. ШУТИС-ийн багш шинээр авах сонгон шалгаруулалтыг нээлттэй явуулах бөгөөд сонгон шалгаруулалт явуулахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон их сургуулийн мэдээллийн сүлжээгээр олон нийтэд зарлана.
- 5.4. Багш шинээр авах асуудлыг сургалтын асуудал хариуцсан дэд захирлаар ахлуулсан “Багш сонгон шалгаруулах ажлын хэсэг” хичээлийн жилийн улирал бүрийн төгсгөлд их сургуулийн хэмжээнд нэгдсэн журмаар зохион байгуулна. Багш сонгон шалгаруулах ажлын хэсэгт тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирал, салбар, тэнхимиийн эрхлэгч оролцно.
- 5.5. Хичээлийн жилийн улирлын явцад багш шинээр авах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зөвхөн ШУТИС-ийн Захирлын зөвшөөрлөөр энэхүү журамд заасны дагуу шийдвэрлэж байна.
- 5.6. Багшийн сонгон шалгаруулалтыг дараах зарчмаар явуулах бөгөөд хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж хариуцан зохион байгуулна. Үүнд:
 - 5.6.1. Шинээр авах багшийн хэрэгцээг тухайн нэгжийн орон тоо, авах шаардлагатай багшийн мэргэжил, заах хичээл, судалгаа шинжилгээний ажлын чиглэл, сургалтын ажлын кредитийн ачаалал (3-аас доошгүй жил тогтвортой ачаалалтай байх) зэрэг үзүүлэлтээр салбар, тэнхим хариуцан гаргаж, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн саналаа сургалтын асуудал эрхэлсэн захиргааны нэгжээр хянуулан, тогтоосон хугацаанд хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.
 - 5.6.2. Багшийн сонгон шалгаруулалтад оролцогч нь магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан хүн холбогдох материалыг бүрдүүлэн, өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Үүнд:
 - 5.6.2.1. Тухайн зарлагдсан мэргэжлээр бакалавр, магистрын боловсролын зэрэг эзэмшсэн байх;
 - 5.6.2.2. Дипломын голч дүн бакалаврын зэрэгт 3.0-аас, магистрын зэрэгт 3.2-аас доошгүй үнэлгээтэй байх (Шалгалтын үнэлгээний өөр системтэй сургууль төгссөн бол ШУТИС-ийн үнэлгээнд дүйцүүлэн тооцно);



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт

- 5.6.2.3. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлний (TOEIC) болон компьютерийн мэдлэгийн түвшин тогтоох тест (ITPassport)-ийн шалгалт өгч тэнцсэн байх;
- 5.6.3. “Багш сонгон шалгаруулах ажлын хэсэг” сонгон шалгаруулалтад орж буй хүн нэг бүртэй ярилцлага хийж, ярилцлагад тэнцсэн хүмүүсээс мэргэжлийн шалгалт авна. Мэргэжлийн шалгалт авах комиссыг хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжийн даргатай зөвшилцөн тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар байгуулж ажиллуулна.
- 5.6.4. Доктор (Ph.D)-ын болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй хүнийг шалгалтуудаас чөлөөлөх бөгөөд ярилцлагаас тохиорох үнэлгээ авсан тохиолдолд тэнцсэнд тооцно. Шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шалгалт авч болно.
- 5.6.5. Мэргэжлийн шалгалтанд ”В”-гээс доoshгүй үнэлгээ авч тэнцэх ба шалгалтанд тэнцээгүй хүний дахин сонгон шалгаруулалтанд орох эрх нь нэг жилийн дараа нээгдэнэ.
- 5.6.6. Гадаад хэлний мэргэжлийн багшийн сонгон шалгаруулалтад оролцох хүн тухайн хэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлний (TOEFL, TOPIK, IELTS, DSH, HSK гэх мэт) шалгалт өгч, зохих оноо авсан байх шаардлагатай.
- 5.6.7. Зохих үнэлгээ авч тэнцсэн хүмүүсийг багшийн ямар албан тушаалд ажиллуулах тухай бүрэлдэхүүн сургуулийн саналыг их сургуулийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Захирлын тушаалаар зохих албан тушаалд ажиллуулна. Захирлын зөвлөлийн хуралд багш шинээр авах салбар, тэнхимиийн эрхлэгчийг биечлэн оролцуулна.
- 5.7. Профессор, багшийн албан тушаалд шинээр ажиллах багшийн мэргэжлийн бус хүмүүс ажилд орсноос хойш 1 жилийн дотор их, дээд сургуульд “Багшлах эрх” авсан байна.
- 5.8. Багш нь ШУТИС-д багшийн албан тушаалд ажиллаж эхэлснээс хойш 10 жилийн дотор докторын зэрэг хамгаалсан байх шаардлагатай. Докторын сургалт дүүргэсэн гэрчилгээ авсан, судалгааны ажил гүйцэтгэж байгаа тохиолдолд дахин 1 жилийн хугацаатай сунгаж болно. Шаардлагыг хангаагүй тохиолдолд цаашид ШУТИС-д ажиллах боломжгүй гэж үзэн хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгоно.

ЗУРГАА. АХМАД БАГШААР АЖИЛЛУУЛАХ

- 6.1. ШУТИС-д ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, эрдмийн зэрэг, цолтой болон ШУТИС-ийн хүндэт профессор цолтой ахмад багшийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын туршлага, ур чадварыг өвлөн авах, эрдэм шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэх, ахисан түвшний сургалтад оролцуулах, мэргэжлийн хичээл заалгах зорилгоор ахмад багшаар ажиллуулж болно.
- 6.2. Ахмад багштай салбар, тэнхимиийн ажлын хэрэгцээ, хичээлийн цагийн ачааллыг харгалзан, холбогдох бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 9 дүгээр сарын
06-ны өдрийн А/168 тоот тушаалын хавсралт

ахлах багшийн албан тушаалын ноогдлын 50, 75, 100 хувийн ачааллаар харгалзуулан гэрээ байгуулж ажиллуулна.

- 6.3. Ахмад багшийн ажиллах нөхцөл, хугацаа, сургалтын ажлын ачаалал, бусад асуудлыг ажил гүйцэтгэх гэрээнд тодорхой зааж зохицуулна. Гэрээг хичээлийн жилийн улирал бүрд бүрэлдэхүүн сургуулийн захирал байгуулах ба ШУТИС-ийн Захирал батална.
- 6.4. Ахмад багшийн ажлын гүйцэтгэлийг тооцоходоо “ШУТИС-ийн профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ыг баримтлана.
- 6.5. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, эрдмийн зэрэг, цолгүй багш нарыг ахмад багшаар ажиллуулахгүй.
- 6.6. Ахмад багшид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл, ээлжийн амралтын олговор, илүү цагийн хөлс олгохгүй.

ДОЛОО. ГЭРЭЭТ БАГШ АЖИЛЛУУЛАХ

- 7.1. Сургалтын үйл ажиллагааны явцад зарим хичээлийг заах профессор багш нар хүрэлцэхгүй байгаа тохиолдолд мэргэжлээрээ магистр болон түүнээс дээш зэрэгтэй, багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх дадлага, туршлагатай хүмүүсийг сургалтын тухайн улиралд гэрээгээр ажиллуулж болно.
- 7.2. Тухайн хичээлийг хариуцсан салбар, тэнхимээс гэрээт багш ажиллуулах саналаа бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлын шийдвэр холбогдох баримт материалын хамт сургалтын асуудал эрхэлсэн захиргааны нэгжид хүргүүлнэ. Сургалтын асуудал эрхэлсэн захиргааны нэгж бүрэлдэхүүн сургуулиудаас ирсэн санал, материалыг хянаж нэгтэн, ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 7.3. Бүрэлдэхүүн сургуулийн захирал гэрээт багш нартай ажиллах нөхцөл, ажлын ачааллыг тусгасан гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллана.